



ГЕРМАНЫ МЭДЭЭЛЛИЙН НОМЫН САН

DEUTSCHE INFORMATIONSBIBLIOTHEK



**GOETHE
INSTITUT**

Sprache. Kultur. Deutschland.





**ГЕРМАНЫ МЭДЭЭЛЛИЙН
НОМЫН САН**

**DEUTSCHE
INFORMATIONSBIBLIOTHEK**



**GOETHE
INSTITUT**

Sprache. Kultur. Deutschland.



Гёте-Институтийн Захирлын мэндчилгээ

Германы мэдээллийн номын сангийн эрхэм уншигчид аа, 10 дугаар сарын 3-ны өдөр бол хоёр Герман улс эргэн нэгдсэн баяр төдийгүй Монгол дахь Гёте-Институтийн үйл ажиллагааны эхлэл тавигдсан тэмдэглэлт өдөр билээ. 2003 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Улаанбаатар хот дахь Хүүхдийн төв номын сангийн дэргэд Германы мэдээллийн номын сан ёслол төгөлдөр нээгдсэн нь Гёте-Институтийн цаашдын олон үйл ажиллагааны эхлэл болж, хожмоо 2009 онд Улаанбаатар хотноо салбараа байгуулах үндэс суурийг тавьсан юм.

Германы мэдээллийн номын сан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн цагаасаа тасралтгүй өргөжин хөгжсөөр ирлээ. Мэдээллийн сангаа ямагт баяжуулан шинэчлэхийн хамт герман хэл, Герман орныг сонирхогчдын хуран цугладаг амьд халуун цэг болсныг номын танилцуулга, уншлага, кино үдэш, төрөл бүрийн хэлэлцүүлэг мэтгэлцээн зэрэг олон арга хэмжээ батлан харуулна.

Энэ бүхнийг ажил хэрэг болгоход 20 жилийн нөр их хөдөлмөрөө зориулсан номын санч Г.Буянцэцэг, Ш.Оюунцэцэг нартаа ойн баярын мэнд хүргэж, онцгойлон талархал илэрхийлье. Түүнчлэн биднийг ямагт дэмжиж, зөвлөн тусалж, ойр дотно хамтран ажилласан Хүүхдийн төв номын сангийн хамт олонд чин сэтгэлээсээ талархаж байна. Эцэст нь Германы мэдээллийн номын санд зочлон үйлчлүүлснээрээ өнөөгийн хэмжээнд хүргэж, уулзан цуглах, мэдээлэл солилцох цэг болгосон бүх уншигчдадда мөн баярлалаа.

Леонхард Хайдэкер
Монгол дахь Гёте-Институтийн захирал



**GOETHE
INSTITUT**

Sprache. Kultur. Deutschland.

Grußwort des Leiters des Goethe-Instituts Mongolei

Liebe Freundinnen und Freunde der Deutschen Informationsbibliothek, der 3. Oktober markiert nicht nur den Tag der Deutschen Einheit, sondern auch den Beginn der Aktivitäten des Goethe-Instituts in der Mongolei. In einer feierlichen Zeremonie wurde am 3. Oktober 2003 die Deutsche Informationsbibliothek in der Zentralbibliothek für Kinder in Ulan Bator eröffnet. Sie diente fortan als Ausgangspunkt für die weiteren Aktivitäten des Goethe-Instituts, die schließlich 2009 in der Gründung des Goethe-Instituts in Ulan Bator mündeten.

Seit ihrer Gründung hat sich die Bibliothek kontinuierlich weiterentwickelt. Nicht nur der Medienbestand wurde ständig erweitert und aktualisiert, die Deutsche Informationsbibliothek wurde auch zu einem lebendigen Treffpunkt für Deutsch- und Deutschlandinteressierte. Zahlreiche Veranstaltungen wie Buchpräsentationen, Lese- und Filmabende sowie Podiumsdiskussionen zu verschiedenen Themen markieren diesen Weg.

Möglich wurde dies durch den unermüdlichen Einsatz unserer beiden Bibliothekarinnen, Buyantsetseg Gombodorj und Oyuntsetseg Shaariibuu, die an diesem Tag auch ihr 20-jähriges Dienstjubiläum feiern und denen unser besonderer Dank gilt. Herzlich bedanken möchten wir uns auch für die gute Zusammenarbeit mit der Zentralbibliothek für Kinder, die uns stets mit Rat und Tat zur Seite stand und steht. Nicht zuletzt gilt unser Dank allen Leserinnen und Besuchern, die die Deutsche Informationsbibliothek zu dem gemacht haben, was sie heute ist: ein Ort der Begegnung und des Austauschs.

Leonhard Heydecker
Leiter des Goethe-Instituts Mongolei



Хүүхдийн төв номын сангийн захирлын мэндчилгээ

Дэлхийн 90 гаруй оронд салбартай германы хэл, соёлыг таниулдаг Гёте-Институттэй хамтран ажилладаг нь бидний хувьд нэр төрийн хэрэг юм. Бид 2003 оноос түншилж, мэдлэгийг түгээсээр ирсэн. Өнөөдрийн байдлаар манай улсын 40 гаруй мянган иргэн германаар ярьж байна. Цаашид хоёр улсын соёл, мэдлэг, мэдээллийн солилцоо хийх бүх чиглэлд Хүүхдийн төв номын сан идэвхтэй хамтран ажиллахад бэлэн байна.

Цаашдаа хоёр орны хүүхэд залуус амьдралын хэв маяг, түүх соёл, зан заншлаа мэдэлцэж, ном соёлын салбарт харилцаа илүү өргөжөөсэй хэмээн хүсэж байна.

Номын сан бол дэлхийн мэдлэгт нэвтрэх гарц болдог, ирээдүйн манлайлагчид номын сангаас л төрдөг, зөвхөн мэдлэгийн уурхай төдий биш тухайн улсын тогтвортой хөгжлийг дэмжих тулгуур болдог. Тийм учраас бид зөвхөн ном уншлага төдийгүй хувь хүний хөгжлийн болон соёлын өвийн сургалт, үзэсгэлэн, хүүхэлдэйн жүжиг, олон төрлийн уралдаан тэмцээн зэргийг зохион байгуулж, соёлын үйл ажиллагаагаа солонгоруулсан.

20 жилийн турш Германы Мэдээллийн Номын Санг дэмжиж, бидэнтэй хамтдаа байгаа Гёте-Институтийн хамт олонд ажил амьдралын сайн бүхнийг ерөөж, хүүхдийн төлөө хийсэн, хийхээр төлөвлөж буй бүхэнд Монголын мянга мянган хүүхэд багачуудын өмнөөс талархал илэрхийлж байна.

С. Хүрэлбаатар

Хүүхдийн төв номын сангийн захирал



Grusswort der Direktorin der Zentralbibliothek für Kinder

Es ist uns eine Ehre, mit dem Goethe-Institut, das die deutsche Sprache und Kultur in mehr als 90 Ländern fördert, zusammenzuarbeiten. Wir arbeiten seit 2003 zusammen und geben unser Wissen weiter. Heute sprechen mehr als 40.000 Bürgerinnen und Bürger unseres Landes Deutsch. Auch in Zukunft ist die Zentralbibliothek für Kinder bereit, in allen Bereichen des Kultur-, Wissens- und Informationsaustauschs zwischen den beiden Ländern aktiv zusammenzuarbeiten.

Ich hoffe, dass die Kinder und Jugendlichen beider Länder in Zukunft die Lebensweise, die Geschichte, die Kultur und die Bräuche des jeweils anderen noch besser verstehen und dass die Beziehung im Bereich der Literatur und Kultur vertieft werden.

Die Bibliothek ist ein Tor zum Wissen, aus ihr gehen zukünftige Führungskräfte hervor. Sie ist nicht nur eine Wissensschmiede, sondern auch eine Stütze für die nachhaltige Entwicklung des Landes. Aus diesem Grund haben wir unsere kulturellen Aktivitäten diversifiziert und organisieren nicht nur Buchlesungen, sondern auch Schulungen zur Persönlichkeitsentwicklung und zum kulturellen Erbe, Ausstellungen, Puppentheater sowie verschiedene Wettbewerbe. Möge dies zum Wohle der Kinder und der Kultur beider Länder geschehen.

Wir wünschen den Mitarbeiterinnen des Goethe-Instituts, die seit 20 Jahren bei uns sind, alles Gute für ihre Arbeit und danken im Namen tausender mongolischer Kinder für alles, was sie für sie getan haben und noch tun werden.

S. Khurelbaatar
Direktorin der Zentralbibliothek für Kinder

ГЕРМАНЫ МЭДЭЭЛЛИЙН НОМЫН САН БАЙГУУЛАГДСАН ТҮҮХ

Герман-монголын хамтын ажиллагааны хүрээнд 2003 оны 10 дугаар сарын 3-ны өдөр Гёте-Институтийн санаачилгаар нэгэн том хуудас нээгдсэн нь тухайн үед Улсын төв номын сангийн харъяанд байсан Хүүхдийн номын ордны байранд Германы Мэдээллийн Номын Сан (ГМНС) байгуулагдсан явдал байлаа. Тус номын сан анх 2000 гаруй ном хэвлэл, 500 гаруй аудио видео материал бүхий сан хөмрөгтэй нээгдэж байсан бол түүнээс хойш зогсолтгүй өргөжин дэвжсээр, өдгөө 7000 гаруй ном хэвлэл, аудио видео материалтай болжээ. Жил бүр 800 гаруй хүн, тэр дундаа Герман оронтой холбогдох шижмийг эрэлхийлсэн хүүхэд залуус тус номын сангаар үйлчлүүлэн, үр шимийг нь хүртэж байна. Өдгөө ГМНС нь герман хэл сурах, Германы орны тухай мэдлэгээ зузаатгахад тус дөхөм болох нэн чухал эх сурвалж болжээ.

GRÜNDUNGSGESCHICHTE DER DEUTSCHEN INFORMATIONSBIBLIOTHEK

Im Rahmen der deutsch-mongolischen kulturellen Zusammenarbeit wurde auf Initiative des Goethe-Instituts am 3. Oktober 2003 ein bedeutendes Kapitel geschrieben: Die Deutsche Informationsbibliothek wurde im Gebäude des Kinderbuchpalasts gegründet, welcher zu jener Zeit der Staatlichen Zentralbibliothek unterstand. Die Informationsbibliothek begann ihre Arbeit mit einer anfänglichen Sammlung von etwa 2.000 Büchern und 500 audiovisuellen Medien. Seitdem ist die Bibliothek stetig gewachsen und beherbergt heute rund 7.000 Bücher und audiovisuelle Medien. Jährlich profitieren mehr als 800 Menschen davon, insbesondere Kinder und Jugendliche, die einen Anknüpfungspunkt an Deutschland suchen. Heute ist die Deutsche Informationsbibliothek eine wertvolle Ressource für die Förderung des Verständnisses der deutschen Sprache und des Wissens über Deutschland.





Он цагийн хэлхээс

CHRONOLOGIE

2003.
10.03.

ГМНС байгуулагдсан.



Die Deutsche Informationsbibliothek wird gegründet.

2004

Ном, аудио видео материалуудыг хоногт 100 төгрөгийн төлбөртэйгээр гэрээр олгож эхэлсэн. Ном олголтын бүртгэлийг гараар бичиж хөтөлдөг байв.

Bücher und audiovisuelle Medien können für eine Gebühr von 100 MNT pro Tag nach Hause ausgeliehen werden; die Ausleihen wurden handschriftlich vermerkt.

ХБНГУ-ын парламентын гишүүд номын санд зочлов.

Mitglieder des Deutschen Bundestages besuchten die Bibliothek.

2005.

ХБНГУ-ын Падерборны их сургуулийн оюутан Мария Бриш ГМНС-д дадлага хийв.

Maria Brysch, Studentin an der Universität Paderborn, absolvierte ein Praktikum in der Deutschen Informationsbibliothek.

2006.

Электрон каталогт ГМНС-ын номыг оруулж эхлэв.



Der Medienbestand der Deutschen Informationsbibliothek wurde in einem elektronischen Katalog erfasst.

Номын шинэ тавиуртай болов.

Die Bibliothek erhält ein neues Bücherregal.

2008

Номын сангийн иж бүрэн программ хангамжтай болов.

Eine umfassende Bibliotheks-Software wurde eingeführt.

2009

Улаанбаатар хотод Гёте-Институтийн салбар байгуулагдав.

Gründung des Goethe-Instituts Mongolei in Ulan Bator



2010

Улаанбаатар хот дахь ХБНГУ-ын ЭСЯ, Германы Эрдмийн солилцооны алба, Гёте-Институтийн Монгол дахь салбар, “Монгол-Германы гүүр” ТББ, Германы мэдээллийн номын сан хамтран Германы боловсролын үзэсгэлэн зохион байгуулав.

Eine deutsche Bildungsmesse wurde von der Deutschen Botschaft Ulan Bator, dem Deutschen Akademischen Austauschdienst, dem Goethe-Institut Mongolei, der Mongolisch-Deutschen Brücke und der Deutschen Informationsbibliothek organisiert.

2012

Зул сарын баяраар ГМНС-аас анх удаа “Азтай уншигч” шалгаруулж, 20 уншигчид бэлэг өгөв.



Am Weihnachtstag haben zum ersten Mal 20 Leserinnen und Leser Überraschungsgeschenke bei einem von der Informationsbibliothek veranstalteten Gewinnspiel erhalten.



2013

Гэрээр олгох үйлчилгээг номын сангийн үйлчилгээний программд шилжүүлж, үнэ төлбөргүй болгов.

Das Ausleihen von Medien wurde kostenlos und erfolgte fortan über die digitale Bibliotheksverwaltungssoftware.

2017

“Ерөнхий боловсролын сургууль: „Ирээдүйн түнш” (PASCH) санаачилгатай хамтран цуврал кино хэлэлцүүлэг хийсэн.



Eine Filmdiskussion wurde von der Initiative „Schulen: Partner der Zukunft“ (PASCH) und der Deutschen Informationsbibliothek organisiert.

2019

Герман, монгол 2 хэл дээрх хүүхдийн номуудыг танилцуулах үзэсгэлэнг цахим хэлбэрээр зохион байгуулав.



Eine digitale Ausstellung von Kinderbüchern auf Mongolisch und Deutsch wurde präsentiert.

2021

“Өвлийн ид шид” зул сарын баяр тэмдэглэв.

Die Weihnachtsfeier „Winterzauber“ wurde veranstaltet.

ГЕРМАНЫ МЭДЭЭЛЛИЙН НОМНЫ САН 20 ЖИЛИЙН ХУГАЦААНД

**DIE DEUTSCHE
INFORMATIONSBIBLIOTHEK
IN 20 JAHREN**



1

Германы мэдээллийн номын сан ба Герман хэл сонирхогчдын нийгэмлэгийн хамтын ажиллагаа

Zusammenarbeit mit der Gesellschaft für deutsche Sprache E. V.

ГМНС нь 2009 оныг хүртэл Герман хэл сонирхогчдын нийгэмлэгтэй нягт хамтран ажиллаж, оюутан суралцагчдад зориулан дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж ирлээ:

- Герман хэлний анхан болон дунд шатны курс
- Герман хэлний олимпиад
- Илтгэл, уулзалт, хэлэлцүүлэг зэрэг соёлын арга хэмжээнүүд
-

Герман хэл сонирхогчдын нийгэмлэг болон “Монгол-Германы гүүр” ТББ-тай хамтран “Германд суралцах боломж” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг их дээд сургуулийн оюутнуудад зохион байгуулав.

Bis 2009 arbeitete die Bibliothek eng mit der „Gesellschaft für deutsche Sprache e. V.“ zusammen und organisierte die folgenden Aktivitäten für Studierende:

- Deutschkurse für Anfänger und Fortgeschrittene
- Deutsche Spracholympiade
- Kulturelle Aktivitäten wie Vorträge, Treffen und Diskussionen
-

In Zusammenarbeit mit der „Gesellschaft für deutsche Sprache e. V.“ und der Nichtregierungsorganisation „Mongolisch-Deutsche Brücke“ wurden Diskussionen und Treffen für Hochschulstudentinnen und -studenten zum Thema „Studienmöglichkeiten in Deutschland“ organisiert.



2

Зул сарын баяр

Weihnachten

ГМНС нь 2005 оноос эхлэн зул сарын баярыг уншигчидтайгаа хамт тэмдэглэх болсон. Ингэхдээ жил бүр уншигчдын дундаас шилдэг уншигчдыг урамшуулж, азтай уншигч шалгаруулан гэнэтийн бэлэг барьж, хөгжөөнт тоглоом тоглож, оньсого таавар тааж, дуу дуулах зэргээр зул сарын баяраа тэмдэглэн өнгөрүүлдэг.

Seit 2005 veranstaltet die Deutsche Informationsbibliothek Weihnachtsfeiern für ihre Leserinnen und Leser. Dabei werden jedes Jahr die aktivsten Leserinnen und Leser mit Überraschungsgeschenken belohnt, lustige Spiele gespielt, knifflige Rätsel gelöst und gemeinsam Lieder gesungen.





3

ГМНС байгуулагдсан ойн өдөр

Jubiläen der Deutschen Informationsbibliothek

ГМНС байгуулагдсаны 1 жилийн ойг тохиолдуулан уншигчдын дунд “Герман орны тухай миний бодол” сэдвээр зохион бичлэгийн уралдаан зарлаж, шалгарсан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргасан. Мөн жил бүр ГМНС нь төрсөн өдрөө тэмдэглэж уншигчдаа идэвхжүүлэн, соёлын олон төрлийн ажлууд зохион байгуулсаар ирсэн.

Anlässlich des ersten Jahrestages der Deutschen Informationsbibliothek 2004 wurde unter den Leserinnen und Lesern ein Aufsatzwettbewerb zum Thema “Meine Gedanken über Deutschland” veranstaltet. Die besten Arbeiten wurden in einer Ausstellung präsentiert, die die Kreativität und das Interesse der Teilnehmerinnen und Teilnehmer widerspiegelte. Seitdem feierte die Deutsche Informationsbibliothek jedes Jahr ihre Gründung mit einer Vielzahl kultureller Aktivitäten.





4

Герман мэдээллийн номын санг танилцуулах “Чиний герман найз” төсөл

Präsentation der Deutschen Informationsbibliothek im Rahmen des Projekts „Dein Deutscher Freund“

2008 онд тус номын сангаар үйлчлүүлэгчдийн арав хүрэхгүй хувийг сургуулийн насныхан эзэлж байв. Энэ хувийг нэмэгдүүлэх, олон нийт тэр дундаа хүүхдүүдийг ГМНС болон германы уран зохиолтой ойртуулан танилцуулахын тулд 2009 онд “Чиний герман найз” төслийг Гёте-Институтийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн юм.

Уг төслийн хүрээнд сан хөмрөгт буй ном, сурах бичгүүдээс сонгон видео, зураг, тайлбар бүхий танилцуулга бэлтгэж, сонирхсон хүүхэд багачуудад үзүүлж эхлэв. Энэхүү төсөл нь гэрээр ном хэвлэл үнэ төлбөргүй олгох, мэдээлэл өгөх зэрэг номын сангийн үндсэн үйлчилгээнээс гадна хүүхдийг номд дурлуулах, номын сангийн байнгын үйлчлүүлэгч болгох боломжийг онцолдог.

Төсөл хэрэгжиж эхэлснээр номын санд үйлчлүүлэхээр ирсэн хүүхэд багачуудад ГМНС-ийн тухай төрөл бүрийн дэлгэрэнгүй танилцуулгыг тогтмол үзүүлдэг болсон нь ГМНС болон Германы уран зохиолын ертөнцийн тухай мэдлэгийг дээшлүүлэхэд тустай ажил болсон юм.

Im Jahr 2008 waren weniger als zehn Prozent der Bibliotheksbesucherinnen und -besucher Schülerinnen und Schüler. Um dieses Verhältnis zu verbessern und der Öffentlichkeit, und dabei insbesondere Kindern, die Deutsche Informationsbibliothek und deutsche Literatur näherzubringen, wurde 2009 das Projekt “Dein deutscher Freund” mit Unterstützung des Goethe-Instituts ins Leben gerufen.

Im Rahmen des Projekts wurde eine Präsentation mit Bildern, Videos und Erläuterungen aus ausgewählten Lehrbüchern erstellt und den interessierten Kindern vorgeführt. Das Projekt hebt die Kernangebote der Bibliothek hervor, wie zum Beispiel die kostenlose Ausleihe von Büchern, den Zugang zu Informationen sowie die Möglichkeit, die Liebe zu Büchern zu fördern und Stammkundin bzw. Stammkunde der Bibliothek zu werden.

Seit Beginn des Projekts werden den Kindern bei ihren Bibliotheksbesuchen regelmäßig diese ausführlichen Präsentationen über die Bibliothek angeboten. Dies hat dazu beigetragen, das Bewusstsein für die Deutsche Informationsbibliothek und die Welt der deutschen Literatur zu stärken.



5

Кино үйл ажиллагаа, уран зохиолын үдэш, зохиолч уншигчдын уулзалт, сонирхолтой хэлэлцүүлгүүд

Filmveranstaltungen, literarische Abende, autorentreffen und anregende Diskussionen

Герман хэл, соёлыг сонирхогч хэн бүхэнд зориулан ГМНС-аас кино үдэш, мэдээлэл солилцох форум, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулдаг. Номын сангийн кино сан хөмрөгт баримтат, хүүхдийн, инээдмийн, уран сайхны кинонууд өргөн сонголттой байдгаас гадна герман хэл суралцахад зориулж хялбаршуулсан кинонууд хүртэл бий.

Тухайлбал 2017 онд “Монгол дахь PASCH сургуулийн сурагчид болон төгсөгчдийн холбоо” -ноос германы уран сайхны “Чик” киногоор тун сонирхолтой хэлэлцүүлэг зохион байгуулсан сайхан жишээг дурдаж болох юм. Номын сангийн зүгээс герман болон монгол хэл дээрх “Чик” номыг сан хөмрөгт шинээр авч, хэлэлцүүлгийн өмнө уншиж танилцах боломжийг оролцогчдод бүрдүүлж өгсөн байв.

Für alle, die sich für die deutsche Sprache und Kultur interessieren, bietet die Deutsche Informationsbibliothek regelmäßig Filmveranstaltungen, Austauschforen und Diskussionsrunden an. Die Filmsammlung umfasst ein breites Spektrum von Dokumentarfilmen, Kinderfilmen, Komödien und Spielfilmen bis hin zu Filmen, die speziell für das Erlernen der deutschen Sprache geeignet sind.

Ein eindrucksvolles Beispiel dafür war 2017, als der „Verein der Schüler und Absolventen der PASCH-Schulen in der Mongolei“ eine lebhaft Diskussionsveranstaltung zum deutschen Film „Tschick“ organisierte. Vor der Diskussion hatten die Teilnehmerinnen und Teilnehmer die Gelegenheit, dass neu erworbene Buch „Tschick“ in deutscher und mongolischer Sprache zu lesen.



6

Ярианы клуб

Sprachclub

Анх нээгдсэн цагаас нь эхлэн ГМНС-д герман хэлний ярианы клуб ажиллаж эхэлсэн бөгөөд сонирхсон хэн бүхэн герман хэлний мэдлэгийн түвшнээсээ үл хамааран оролцох боломжтой. Сонирхол нэгтнүүдтэйгээ германаар ярилцах боломжийг олгодог энэхүү ярианы клуб олгож, номын сан маань герман хэл сонирхогч хэн бүхний уулзах газар болжээ.

Seit der Eröffnung der Deutschen Informationsbibliothek wird der Sprachclub angeboten. Unabhängig vom Deutschniveau sind Interessierte herzlich zur Teilnahme eingeladen. Die Bibliothek ist ein Ort der Begegnung für Menschen, die sich für die deutsche Sprache interessieren und der Sprachclub bietet die Möglichkeit, mit Gleichgesinnten Deutsch zu sprechen.



7

Уншлагын үдэш - Хүүхдүүд, томчуудад зориулсан мартагдашгүй адал явдал

Lesenacht - ein unvergessliches Erlebnis für Kinder und Erwachsene

Тус номын сан 2013 оноос эхлэн хүүхэд багачуудад мартагдашгүй сайхан дурсамж үлдээх, номын сангийн тухай таатай сэтгэгдэл төрүүлэх, уран зохиолд шимтэн дурлахад нь түлхэц болох зорилгоор “Уншлагын үдэш” арга хэмжээг Гёте-Институтийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж ирлээ.

Өнгөрсөн хугацаанд “Уншлагын үдэш” арга хэмжээг герман хэлний мэдлэгтэй есөөс арван насны сурагчдыг оролцуулан 20 удаа зохион байгуулж, Улаанбаатар хотын 1, 18, 38, 48, 50 дугаар сургуулийн 320 гаруй хүүхэд хамрагджээ. Тус арга хэмжээнд ирэхдээ хүүхдүүд аяны хөнжил, шүдний оо, сойзоо авчран номын санд хонож, найз нөхөд, герман хэлний багш нартайгаа мартагдашгүй үдшийг өнгөрүүлдэг.

Энэ хөтөлбөрийн үеэр бяцхан уншигчид маань номын сантай бүтээлч байдлаар танилцах, хөгжилдөж тоглох, хүүхдийн кино үзэх, ном унших, найз нөхөдтэйгээ уншсан номоо ярилцах боломжтой. Мөн оройн хоол, өглөөний цайгаа номын санд хамтдаа иддэг.

Түүнчлэн Хүүхдийн төв номын сангийн ажилтан оролцогч хүүхдүүдийн эцэг эхчүүдэд “Хүүхэд номтой харьцах нь”, “Уншлагын эрүүл ахуй” сэдвээр сургалт явуулдаг.





Seit 2013 veranstaltet die Deutsche Informationsbibliothek mit der Unterstützung des Goethe-Instituts die „Lesenacht“ mit dem Ziel, Kindern schöne und bleibende Erinnerungen zu schaffen, ihnen positive Eindrücke von der Bibliothek zu vermitteln und die Liebe zur Welt der Literatur zu fördern.

In den letzten Jahren wurde die „Lesenacht“ bereits 20-mal für Schülerinnen und Schüler im Alter von neun bis zehn Jahren mit Deutschkenntnissen organisiert. Mehr als 320 Kinder aus den Schulen 1, 18, 38, 48 und 50 in Ulan Bator haben daran teilgenommen. Für die „Lesenacht“ bringen die Kinder Schlafsäcke, Zahnpasta und Zahnbürsten mit, um gemeinsam mit ihren Freundinnen und Freunden und ihren Deutschlehrerinnen und -lehrern eine unvergessliche Nacht in der Bibliothek zu verbringen.

Die jungen Gäste haben die Möglichkeit, die Bibliothek auf kreative Weise zu erkunden, sich beim Spielen zu entspannen, Kinderfilme anzuschauen, Bücher zu lesen und sich mit ihren Freundinnen und Freunden über das Gelesene

auszutauschen. Gemeinsame Mahlzeiten sind ebenfalls Teil des Programms. Zusätzlich führt eine Mitarbeiterin der Zentralbibliothek, für Kinder, Schulungen für die Eltern der teilnehmenden Kinder zu den Themen „Kinder und ihre Beziehung zu Büchern“ und „Lesehygiene“ durch.







8

Хоёр хэлний номын уншлага - Номын ертөнцөөр аялах нь

Zweisprachige Buchlesung - eine Reise in die Welt der Bücher

Хоёр хэлний уншлага нь тус номын сангаас герман болон монгол хэлээр хэвлэгдсэн хувилбаруудыг нь авч унших боломжтой ном зохиолуудыг уншигч олонд танилцуулах зорилготой. Энэ зорилгын хүрээнд тухайн номын зохиогч юм уу орчуулагч уригдан ирж, номын хэсгээс герман болон монгол хэлээр уншиж өгдөг. Хоёр хэлний уншлага нь зохиолч, орчуулагчтай уулзаж танилцах, уг зохиолын тухай хүссэн асуултаа асууж сонирхох боломжийг уншигчдад олгодог.

Ziel der zweisprachigen Buchlesungen ist es, die Bücher aus der Bibliothek in deutscher sowie in mongolischer Sprache einer breiteren Leserschaft bekannt zu machen. Zu diesem Zweck werden die Autorin und/oder der Übersetzer des jeweiligen Buchs eingeladen, um einen Abschnitt sowohl auf Deutsch als auch auf Mongolisch vorzulesen. Die zweisprachige Lesung bietet den Leserinnen und Lesern Gelegenheit, die Autorin und/oder den Übersetzer persönlich kennenzulernen und Antworten auf alle Fragen rund um das Buch und seine Entstehung zu erhalten.





9

Соёлын хамтын ажиллагаа: Номын сангийн ажилтнуудад зориулсан сургалт семинар

ХБНГУ-ын Вюрцбург хотын номын сангийн захирал, Гёте-Институтийн “Мэдээлэл, номын сан”-гийн зөвлөлийн дарга др. хатагтай Ханнелоре Фогт Монгол улсад 2 удаа зочлон ирж, номын санчдад мэргэжил дээшлүүлэх сургалт семинар зохион байгуулсан.

Сургалтанд Герман улсын нийтийн номын сангийн туршлагыг таниулж, монголын номын сангуудын үйл ажиллагааны талаар номын санчидтай харилцан ярилцсан.

2008 он. “Номын сан үйлчилгээний жишиг болох нь – хэрэглэгчдэд чиглэсэн удирдлага ба менежментийн асуудлууд” сургалт

2013 он. “Үргэлж нэг алхмын урд” номын сангийн шинэлэг санаачилга сургалт семинар
Эдгээр сургалт семинарууд нь Монголын номын сангийн ажилтнуудыг үнэ цэнтэй мэдлэг, туршлагаас суралцахад тусалсан.

Бид Герман оронтой танилцаж, мэргэжил нэгт хүмүүстэй санал бодлоо солилцон, шинэ соргог санааг ажил хэрэгтээ тусган авдаг.

Герман улсад зочилсон аялалаас олж авсан мэдлэг туршлага, шинэ санаагаа Хүүхдийн төв номын сангийнхаа ажилтнуудад хуваалцдаг. Мөн манайд зочилсон хот хөдөөгийн номын санчдад таниулж, харилцан мэдээллээ солилцдог.

Эдгээр зочлол нь бидний мэдлэгийг өргөжүүлэх, алсын хараагаа тэлэх үнэ цэнтэй боломж юм.



Kulturelle Zusammenarbeit & Fortbildungsseminare für das Bibliothekspersonal

Die kulturelle Zusammenarbeit zwischen Deutschland und der Mongolei zeigt sich auch in der Weiterbildung des Bibliothekspersonals. Unter der Leitung von Frau Dr. Hannelore Vogt, der damaligen Direktorin der Stadtbibliothek Würzburg und Vorsitzenden des Beirats "Information und Bibliothek" des Goethe-Instituts, wurden in der Mongolei zwei wichtige Schulungsseminare für Bibliothekarinnen und Bibliothekare durchgeführt. Frau Dr. Vogt vermittelte dabei wertvolle Einblicke in das öffentliche Bibliothekswesen in Deutschland und diskutierte intensiv mit den Teilnehmenden über die Aktivitäten der mongolischen Bibliotheken.

Im Jahr 2008 stand das Seminar unter dem Thema "Bibliothek als Dienstleistungsstandard – Benutzerorientierte Führung und Managementthemen", 2013 folgte ein Fortbildungsseminar zur Bibliotheksinnovationsinitiative "Immer einen Schritt voraus". Diese Workshops halfen mongolischen Bibliothekarinnen und Bibliothekaren, wertvolles Wissen und Erfahrungen zu sammeln und ermöglichten den Fortbildenden einen Perspektivwechsel.

МАНАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Германы мэдээллийн номын сан нь хичээл сургуульдаа болон хувийн хэрэгцээндээ хэрэглэх боломжтой олон төрлийн ном сурах бичиг, материалаар үйлчилдэг. Манай номын сангаас та бүхэн дараах төрлийн материалыг ашиглах боломжтой:

- Герман хэлний сурах бичиг, дасгалын номууд
- Орчин үеийн болон сонгодог уран зохиол
- Хүүхэд, залуучуудад зориулсан уран зохиол
- Сонсдог ном, хөгжмийн цомог, уран сайхны болон баримтат киноны DVD
- Герман сонин, сэтгүүлүүд

Бидний зорилго бол хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангах, герман хэл соёлтой танилцахад тус дөхөм болохуйц өргөн хүрээт баялаг сан хөмрөгөөр үйлчлэхэд оршино.



UNSERE DIENSTLEISTUNGEN UND MEDIENANGEBOTE



Die Deutsche Informationsbibliothek bietet eine große Auswahl an Medien und Materialien, die sowohl im Unterricht als auch zu Hause genutzt werden können. Zu unseren verfügbaren Materialien gehören:

- Deutsche Lehr- und Übungsbücher
- Moderne und klassische Literatur
- Kinder- und Jugendliteratur
- Hörbücher, Musikalben, Spielfilme und Dokumentationen auf DVD
- Deutschsprachige Zeitungen und Zeitschriften

Unser Ziel ist es, eine vielfältige und umfassende Sammlung bereitzustellen, um den Bedürfnissen unserer Nutzerinnen und Nutzer gerecht zu werden und den Zugang zur deutschen Kultur und Sprache zu fördern.



МАНАЙ КАТАЛОГ

Бид сан хөмрөгөө электрон каталогт нийтэд нээлттэй байршуулсан тул дараах вэб сайтад хандсанаар та бүхэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран зочлох боломжтой:

UNSER KATALOG

Unsere umfangreiche Sammlung steht der Öffentlichkeit über einen elektronischen Katalog rund um die Uhr zur Verfügung. Sie können den Katalog jederzeit besuchen, unabhängig von Ort und Zeit, indem Sie die folgende Website aufrufen:

Электрон каталогт
зочлох:

Rufen Sie bitte die
folgende Website auf:

mccl.lib4u.net





Onleihe - Цахим номын сан

Onleihe нь Гёте-Институтийн цахим номын сангийн үйлчилгээ юм. Тус үйлчилгээ 2016 онд Монгол Улсад нэвтэрснээр та гэрээсээ ч гарах шаардлагагүйгээр цахим ном, дуу бичлэг, сэтгүүл зэргийг тодорхой хугацаанд түрээслэх боломж бүрдсэн.

Герман хэл дээрх 35,000 гаруй

- Цахим ном
- Сонсдог ном
- Кино
- Герман хэл суралцагчдад зориулсан материал
- Сонин сэтгүүлийг

Манай Onleihe цахим номын сангаас хаа байгаа газраасаа, хүссэн цагтаа үнэ төлбөргүй татан авч хэрэглэх боломжтой.

Манай Onleihe цахим номын сангаар зочлоорой:



Onleihe - Die digitale Bibliothek

Die Onleihe ist der Online-Bibliotheksservice des Goethe-Instituts. Seit der Einführung in der Mongolei im Jahr 2016 können Sie E-Books, Hörbücher und Zeitschriften für einen bestimmten Zeitraum ausleihen, ohne das Haus verlassen zu müssen.

Mehr als 35.000 deutschsprachige

- E-Books,
- Hörbücher,
- Filme,
- Materialien für Deutschlernende sowie
- Zeitungen und Zeitschriften

können jederzeit und überall kostenlos in unserer Online-Bibliothek heruntergeladen werden.

Besuchen Sie unsere Online-Bibliothek:





Орчуулгыг дэмжих хөтөлбөр

Гёте-Институтийн хэрэгжүүлдэг “Германы утга зохиолыг гадаад хэлнээ хөрвүүлэх” хөтөлбөр нь герман хэл дээрх зохиол бүтээлийг орчуулан хэвлэж буй хэвлэлийн газруудад дэмжлэг үзүүлдэг. Хөтөлбөрийн зорилго нь орчин цагийн утга зохиол, хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан уран зохиол, шинжлэх ухааны голлох бүтээлүүдийг герман бус хэлт уншигч олны хүртээл болгоход оршино.

Гёте-Институтийн дэмжлэгтэй орчуулагдсан ном зохиолуудтай танилцах:



Übersetzungsförderungsprogramm

Das Übersetzungsförderungsprogramm des Goethe-Instituts unterstützt Verlage bei der Übersetzung und Veröffentlichung deutschsprachiger Werke. Ziel des Programms ist es, die Hauptwerke der Gegenwartsliteratur, der Kinder- und Jugendliteratur und der Wissenschaft einem nicht deutschsprachigen Publikum zugänglich zu machen.

Hier finden Sie eine Übersicht der ins Mongolische übersetzten Werke:



Герман номын сангийн уншигчдын сэтгэгдэл:



Би Германы мэдээллийн номын сангаар 10 жилийн турш үйлчлүүлж байна. Тус номын сан нь герман хэл соёлыг сонирхогчдод зориулан сурах бичиг, шалгалтын материал, мэргэжлийн номууд, кино хөгжим зэрэг медиа материалыг тав тухтай орчинд судлах боломжийг бүрдүүлсэн нь ихэд таалагдаж байнгын үйлчлүүлэгч болсон юм. Найрсаг үйлчилгээтэй номын сангийн хамт олондоо амжилт хүсье.

Оюунтөр овогтой Цоо



Leserkommentare zur Deutschen Informationsbibliothek:



Ich besuche die Deutsche Informationsbibliothek seit zehn Jahren. Die Bibliothek bietet allen, die sich für die deutsche Sprache und Kultur interessieren, eine angenehme Umgebung, um Lehrbücher, Prüfungsmaterialien, Fachliteratur sowie Filme und Musik zu studieren, was zu einer großen Beliebtheit und Stammkundschaft führte. Ich wünsche unserem freundlichen Bibliothekspersonal weiterhin viel Erfolg.

Tsoo Oyuntur





“

Би энэ жил 8 дахь жилдээ энэ номын санд сууж үйлчлүүлж байна. Хамгийн анх 6 дугаар ангид сурч байхдаа анх орж ирээд, герман хэлийг сурахад хэрэгтэй ийм олон эх сурвалж бэлэн буйг хараад гайхаж байсан. Ном, шалгалтын материал, аудио материал, ярианы клуб гээд бүхий л талын чадвараа хөгжүүлэх, суралцах бүрэн боломжийг бүрдүүлж өгдөгт нь үнэхээр талархдаг.

Уг танхимд ирж хичээлээ хийх нь хамгийн тухтай байдаг учир байнга ирдэг зуршилтай болчихсон. Зохион байгуулдаг үйл ажиллагаанд нь оролцож, герман соёлыг сонирхол нэгтэй хүмүүстэй хамт мэдэрч, тэмдэглэж байсан нь эргээд бодоход дурсамжтай.

Мартагдашгүй-Эрдэнэ овогтой Мөнгөнчимэг

”

“

Dies ist das 8. Jahr, in dem ich die Deutsche Informationsbibliothek besuche. Als ich in die 6. Klasse kam, war ich überrascht, dass es so viele Ressourcen zum Deutschlernen gibt. Ich schätze es sehr, dass die Bibliothek ein umfassendes Angebot an Lernmöglichkeiten bietet, darunter Bücher, Prüfungsmaterialien, Audiomaterialien und Sprachclubs.

Es ist der angenehmste Ort zum Lernen, deshalb bin ich eine regelmäßige Besucherin geworden. Es ist sehr schön, die deutsche Kultur mit Gleichgesinnten zu erleben und zu feiern, indem man an den Aktivitäten teilnimmt.

Mungunchimeg Martagdashgui-Erdene

”



Гомбодоржийн Буянцэцэг
Германы мэдээллийн номын сан
Номын санч

Buyantsetseg Gombodorj
Bibliothekarin der Deutschen
Informationsbibliothek



Шаарийбуугийн Оюунцэцэг
Германы мэдээллийн номын сан
Номын санч

Oyuntsetseg Shaariibuu
Bibliothekarin der Deutschen
Informationsbibliothek



IMPRESSUM

Herausgeber
Goethe-Institut Mongolei 2023

Хэвлэн нийтлүүлэгч
Монгол дахь Гёте-Институт 2023 он

Redaktionsleitung
Leonhard Heydecker

Ахлах редактор
Леонхард Хайдэкер

Redaktionsteam
Buyantsetseg Gombodorj
Oyuntsetseg Shaariibuu
Enkhjargal Altangerelt
Luisa Marie Link

Редакцын баг
Гомбодоржийн Буянцэцэг
Шаарийбуугийн Оюунцэцэг
Алтангэрэлтийн Энхжаргал
Луиза Marie Линк

Design Gamma Photo Agency

Эхийг Гаммафото агентлаг

Foto von:

Seite 4 Felikss Francer
Seite 8 Deutsche Informationsbibliothek (Buyantsetseg Gombodorj)
Seite 9 Deutsche Informationsbibliothek (Oyuntsetseg Shaariibuu)
Seite 12 Goethe-Institut Mongolei (Rentsendorj Bazarsukh)
Seite 13 Deutsche Informationsbibliothek (Buyantsetseg Gombodorj)
Seite 14 Goethe-Institut Mongolei (Rentsendorj Bazarsukh)
Seite 15 Deutsche Informationsbibliothek (Oyuntsetseg Shaariibuu)
Seite 16 Goethe-Institut Mongolei (Rentsendorj Bazarsukh)
Seite 17 Deutsche Informationsbibliothek (Buyantsetseg Gombodorj)
Seite 18 Deutsche Informationsbibliothek (Oyuntsetseg Shaariibuu)
Seiten 19-21 Goethe-Institut Mongolei (Rentsendorj Bazarsukh)
Seiten 22-23 Mongolisches Bibliothekskonsortium (Gantulga Lkhagva)
Seiten 24-26 Goethe-Institut Mongolei (Rentsendorj Bazarsukh)
Seite 27 Deutsche Informationsbibliothek (Buyantsetseg Gombodorj)
Seiten 28-29 Deutsche Informationsbibliothek (Buyantsetseg Gombodorj)

DEUTSCHE
INFORMATIONSBIBLIOTHEK

ГЕРМАНЫ МЭДЭЭЛЛИЙН
НОМЫН САН

Sukhbaatar Bezirk, 8. Khoroо,
Kulturpalast Gebäude B

Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Соёлын төв өргөө Б корпус

Kontakt / Холбоо барих
Tel / Утас: +976 70118333
E-mail / Цахим хаяг: deutsche.infobib@gmail.com

Website: <https://www.goethe.de/ins/mn/de/kul/bib.html>



**ГЕРМАНЫ МЭДЭЭЛЛИЙН
НОМЫН САН**

**DEUTSCHE
INFORMATIONSBIBLIOTHEK**

